



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 5/61

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хурх тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Л.Энхтуяа нь өөр ажилд шилжин ажиллах болсон тул 2017 оны 3 сарын 21-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг цуцалж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. Эрхлэгчийн ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг тосгоны Захирагч /Г.Нацагдорж/-д даалгасугай.

Гурав. Эрхлэгчтэй зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгахыг цэцэрлэгийн нягтлан бодогч /Б.Оюунтуяа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА